



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 136

Хархорин сум

Г Дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, 9.6, 9.7, 9.8 дахь заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 26-ний өдрийн “Хорио цээрийн дэглэмийг цуцалж хязгаарлалтын дэглэм тогтоох тухай” А/232 дугаар захирамжийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Гоц халдварт хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг хийж гүйцэтгэх, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Лхагвасүрэн (Засаг даргын орлогч)

Гишүүд: Ц.Пүрвээ (“Дэлийн бүрд” мал эмнэлгийн захирал)

А.Сайнбилэг (“Аяган зураа” мал эмнэлгийн захирал)

Т.Алтангэрэл (1 дүгээр багийн Засаг дарга)

Р.Сүхбат (2 дугаар багийн Засаг дарга)

Д.Батчулуун (3 дугаар багийн Засаг дарга)

Г.Отгонбаяр (4 дүгээр багийн Засаг дарга)

Б.Ганхуяг (5 дугаар багийн Засаг дарга)

Л.Төгөлдөр (6 дугаар багийн Засаг дарга)

О.Батсүх (7 дугаар багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Э.Нарангарав (Мал эмнэлгийн тасгийн дарга)

2. Гоц халдварт хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 30 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

3. Дархлаажуулалтын товыг малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нарт зарлан мэдээлж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Товлосон хугацаанд мал, амьтныг бэлэн байлгаж, бүрэн хамруулж, барьж бэхлэн, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлэх, малын эмчийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг малчин, мал бүхий иргэдэд үүрэг болгосугай.

5. Мал, амьтны гоц халдварт хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг мэргэжил арга зүйгээр хангаж, ажлын явц үр дүнд хяналт